"Сэлбэ хорин минутын хот корпорац" ХХК-ийн 110/35/10 кВ-ын 2х40 МВА хүчин чадалтай дэд станц шинээр барих

ТЕХНИКИЙН НӨХЦӨЛ

Олгосон огноо: 2025.02.21 №25/2025 Улаанбаатар хот

1. Техникийн нөхцөл хүссэн иргэн, хуулийн этгээдийн нэр, хаяг	Хот байгуулалт, хотын стандартын газар Улаанбаатар хот, ХУД, 23-р хороо
2. Техникийн нөхцөл хүссэн байршил	Чингэлтэй дүүргийн 18-р хороо, Сүхбаатар дүүргийн 13,14-р хороо, Сэлбэ дэд төв
3. Ажил үйлчилгээний зориулалт	"Сэлбэ дэд төв" орчмын өсөн нэмэгдэж буй хэрэглээг хангах,
4. Техникийн нөхцөл олгох, сунгах үндэслэл	4.1 Улсын бүртгэлийн 2117401 дугаартай гэрчилгээ, 4.2 Нийслэлийн засаг даргын эдийн засаг, дэд бүтцийн асуудал хариуцсан нэгдүгээр орлогчийн баталсан 2023 оны 11 дүгээр сарын 27-ний 2023/11 дугаартай ажлын даалгавар, 4.3 Хот байгуулалт, хотын стандартын газрын www.itc.energy.mn цахим системээр гаргасан хүсэлт, 4.4 Хот байгуулалт, хотын стандартын газрын 2025 оны 02 дүгээр сарын 04-ны өдрийн 01/131 тоот албан бичиг,
5. Олгосон чадал	5.1 110/35/10 кВ-ын 2х40 МВА хүчин чадалтай дэд станц барих.
6. Тоолуур, хэмжих хэрэгсэлд тавигдах шаардлага	6.1 Монгол Улсын Засгийн газрын тохируулагч агентлаг-Стандарт, хэмжилзүйн газрын загварын туршилт орж, ашиглахыг зөвшөөрч, баталгаажуулсан байх. 6.2 RS-485-ийн гаралтын интерфэйстэй олон улсын IEC61107, IEC62056 холболтын стандартуудын шаардлага хангасан байх, 6.3 Санах ой бүхий 0.2 нарийвчлалтай бүрэн электрон тоолуур суурилуулах. 6.4 Шинээр суурилуулж буй тоолуурууд нь тоолуурын нэгдсэн системд холбох. Мэдээлэл дамжуулах боломжийг бүрдүүлсэн байх. 6.5 Тоолуур, хянах, хэмжих хэрэгсэлд

	тавигдах шаардлагыг хангагч байгууллага “ДҮТ” ТӨХХК, “ЦДҮС” ТӨХК-иудаас авах. Ажлын зураг төсөл боловсруулах шатанд суурилуулах тоолуурын төрөл, марк, схемийг тухайн байгууллагаар хянуулсан байх,
7. Гүйдлийн трансформаторт тавигдах шаардлага	7.1 Монгол Улсын Засгийн газрын тохируулагч агентлаг-Стандарт, хэмжилзүйн газрын загварын туршилт орон, ашиглахыг зөвшөөрч, баталгаажуулсан байх. 7.2 Холбогдох тооцооны дагуу ачаалал хэрэглээнд тохирсон коэффициент бүхий гүйдлийн трансформатор суурилуулах. 7.3 Олон улсын IEC 61869-2 стандартын шаардлагыг хангасан, реле хамгаалалт, хэмжүүр, хянах хэмжих хэрэгсэлд тавигдах шаардлагуудыг бүрэн хангасан, 0.2 нарийвчлалтай гүйдлийн трансформатор суурилуулах,
8. Холбогдох цэг	8.1 110 кВ-ын 135, 136-р ЦДАШ-ыг шинээр баригдах 110/35/10 кВ дэд станцын 110 кВ-ын ил хуваарилах байгууламжаар орж гарсан схемтэй байх,
9. Дамжуулах, түгээх сүлжээний шугам, дэд станцыг өргөтгөх шаардлага	9.1 110/35/10 кВ-ын “Сэлбэ дэд төв” дэд станц: 9.1.1 110 кВ-ын шинэ гаргалгаа тус бүрд IEC олон улсын стандартын шаардлага хангасан хүчдэл, гүйдлийн трансформатор, алсын удирдлагатай элегаз таслуур, газардуулгын хутга бүхий хуурай салгуур, цэнэг шавхагч, реле хамгаалалт автоматик, хянах хэмжих хэрэгслүүдээр тоноглох, 9.1.2 110 кВ-ын гаргалгаануудын шинийн дифференциал хамгаалалтын хэлхээнд оруулах, УРОВ тавих. Зураг төсөл боловсруулах шатанд “ЦДҮС” ТӨХК-тай зөвшилцөх, 9.1.3 Аваарын үеийн процессыг бүртгэх төхөөрөмжөөр тоноглох. Зураг төсөл боловсруулах шатанд “ДҮТ” ТӨХХК-тай зөвшилцөх, 9.1.4 Өргөтгөлийн ажилтай холбогдуулан, 110 кВ-ын хуваарилах байгууламжийн шин, дамжуулагч утас, изоляторууд болон бусад цахилгаан тоноглолуудыг зураг төслийн шатанд тооцоогоор сонгож, ашиглагч “ЦДҮС” ТӨХК-тай зөвшилцөх, шаардлагатай тохиолдолд өргөтгөн шинэчлэх, 9.1.5 Ачаалал нэмэгдэж байгаа тул 110 кВ-ын хуваарилах байгууламжийн систем шинийн үндсэн болон бэлтгэл хамгаалалтуудыг тооцоо хийж, зураг төсөл боловсруулах шатанд ашиглагч “ЦДҮС” ТӨХК-тай зөвшилцөн сонгох, шаардлагатай тохиолдолд өргөтгөн шинэчлэх,

9.1.6 Зураг төсөл боловсруулах шатанд дэд станцын аянгын хамгаалалт, газардуулгын байгууламжийн тооцоо, хэмжилтийг хийж, тогтоосон дүрэм журмын шаардлагад хүргэх,
9.2 Шинээр баригдах 110 кВ-ын 2 хэлхээт цахилгаан дамжуулах агаарын шугам:
9.2.1 110 кВ-ын цахилгаан дамжуулах агаарын шугам нь MNS 6522:2015 стандартын шаардлага хангасан 2 хэлхээтэй байх,
9.2.2 131, 132, 137, 138-р ЦДАШ-ын хөндлөн огтлолыг АС-300/39 -аас багагүй байхаар нэмэгдүүлэх,
9.2.3 Дамжуулагчийн хөндлөн огтлолыг тооцоогоор сонгох, мөн утасны механик ачаалалд тохирсон үндсэн хийцүүд, хөндийрүүлэгч элементүүдийг тооцоогоор сонгох, зураг төслийн шатанд ашиглагч "ДҮТ" ТӨХХК, "ЦДҮС" ТӨХК-уудтай зөвшилцөх.
9.2.4 Шугам нь мэдээлэл дамжуулах бололцоотой шилэн кабель бүхий аянгын тросстой байх, ашиглагч байгууллага "ДҮТ" ТӨХХК, "ЦДҮС" ТӨХК-уудтай зөвшилцөх.
9.2.5 Цахилгаан дамжуулах агаарын шугамын үндсэн хийц болох анкер болон завсрын тулгуур нь төмөр болон төмөрбетон байх,
9.2.6 Цахилгаан дамжуулах агаарын шугамын үндсэн хийцүүд, дамжуулагч утас, шилэн кабель бүхий аянгын тросс, хөндийрүүлэгч элементүүд, утас угсралтын тоног төхөөрөмжүүд нь Монгол улсын стандартын шаардлага хангасан байх, тухай газрын байгаль цаг уур, газарзүйн онцлогийг харгалзан зураг төслөөр сонгох,
9.2.7 Цахилгаан дамжуулах агаарын шугамд сүүлийн үеийн микро процессор бүхий үндсэн болон бэлтгэл хамгаалалтыг суурилуулах, удирдах щитны (HMI) удирдах, хянах, холбогдох, ашиглагч байгууллага "ДҮТ" ТӨХХК, "ЦДҮС" ТӨХК-уудтай зөвшилцөх.
9.2.8 Шинээр суурилуулах тоолууруудыг тоолуурын нэгдсэн системд холбох.
9.2.9 Цахилгаан дамжуулах агаарын шугамын трассыг одоо байгаа болон ойрын хугацаанд баригдахаар төлөвлөгдсөн бусад шугамын гаргалгаа, трасстай аль болох огтлолцохгүй байхаар төлөвлөн, зураг төслийн шатанд “ЦДҮС” ТӨХК-тай зөвшилцөн сонгох,
9.3 110/35/10 кВ-ын дэд станц:
9.3.1 Дэд станц нь 110/35/10 кВ-ын трансформатортай байх бөгөөд хүчин чадлыг хэрэглээг ачаалалтай уялдуулан тооцоогоор сонгох.
9.3.2 Хүчний трансформатор нь ачаалалтайгаар хүчдэл тохируулагч /РПН/-тай байх. РПН-ны тавилыг автоматаар өөрчлөх төхөөрөмж

суурилуулах ба тогтмол гүйдлийн хэлхээнээс тэжээгддэг байх, Хэвийн хүчдэлийн 1.25-аас багагүй, 1.6-аас ихгүй хэмжээтэйгээр өөрчлөх боломжтой, 17-аас доошгүй тавилтай байх,

9.3.3 Дэд станцын хүчний трансформаторууд нь олон улсын IEC 60076-10 стандартын шаардлагыг хангасан байх,

9.3.4 Шинээр тавигдах 110 кВ-ын хүчний трансформаторуудын оруулга тус бүрд тооцоогоор цэнэг шавхагч сонгож суурилуулах,

9.3.5 Хүчний трансформаторын хөргөлтийн систем нь албадмал болон үлээлгэн байх,

9.3.6 Трансформаторын чадалд тохирсон 110 кВ, 35 кВ, 10 кВ-ын шинийн утас, түүний механик ачаалалд тохирсон шинийн портал, тусгаарлагч элемент, дагалдах төмөр хийцүүдийг тооцоогоор сонгох,

9.3.7 Трансформаторын суурийн тооцоог зураг төслийн шатанд хийж, барилгын мэргэжлийн байгууллагаар дүгнэлт гаргуулан, түүнийг үндэслэн суурийг хийж гүйцэтгэх,

9.3.8 Дэд станцын 35 кВ-ын I ба II секцээс кабель шугам татаж 35 кВ-ын "Төгөл" дэд станцтай холбох.

9.3.9 Дэд станцын 10 кВ-ын I ба II секцээс кабель шугам татаж РП хуваарилах байгууламжууд барьж тэжээх,Микропроцессорын хамгаалалтыг SCADA системд холбох.

9.3.10 Шинээр баригдах РП хуваарилах байгууламжуудын 10 кВ-ын I ба II секцээс кабель шугам татаж дэвшилтэт технологи бүхий ХТП дэд өртөөнүүд барьж тэжээх. Схем горимыг УБЦТС ТӨХК-тай зураг төслийн шатанд зөвшилцөх.

9.4 Дэд станцын 110 кВ-ын хуваарилах байгууламж:

9.4.1 110 кВ-ын I,II систем шинтэй, гарсан шугамын 4, хүчний трансформаторын 2, секц холбогч таслуурын 1 таслууртай байх, Зураг төсөл боловсруулах шатанд ашиглагч байгууллага “ЦДҮС” ТӨХК-тай зөвшилцөх,

9.4.2 110/35/10 кВ-ын 2х40 МВА суурилагдсан чадал бүхий 2 хүчний ТР-тай байх,

9.4.3 110 кВ-ын гаргалгаа тус бүрд олон улсын IEC стандартын шаардлага хангасан, алсын удирдлагатай элегаз таслуур болон дагалдах тоноглолын хамт, газардуулгын хутга, цахилгаан соронзон хоригтой хуурай салгуур, цэнэг шавхагч, реле хамгаалалт автоматик, хянах хэмжих хэрэгсэл бүхий ячейкуудтай байх,

9.4.4 110 кВ-ын систем шин нь шугамын, трансформаторын, хуурай салгуур нь тус бүртээ ячейктай байх,

9.4.5 110 кВ-ын таслууруудыг АПВ

төхөөрөмжөөр болон удирдлагын түлхүүрээр /гараар/ синхрон хяналттай залгах боломжтой байх. Синхрон хяналтын мэдээллийг /шугам, шинийн хүчдэл, өнцөг, давтамж/ хүчдэлийн трансформатороос авч байх.

9.4.6 АПВ-гийн төхөөрөмжийг шугамын хүчдэл ба шинийн хүчдэл хянах боломжтойгоор сонгох,

9.4.7 110 кВ-ын гаргалгаа болон трансформаторуудын гаргалгаа тус бүрд ачаалалд тохирсон коэффициент бүхий гүйдэл, хүчдэл, бодит, хуурмаг чадлын хэмжүүр тавих,

9.4.8 110 кВ-ын хуваарилах байгууламжийн шинийн болон шугам, трансформаторуудын үндсэн, бэлтгэл хамгаалалтуудыг олон улсын IEC-61000, IEC-60258, IEC-60068, IEC-61850 зэрэг стандартын шаардлага хангасан орчин үеийн микропроцессорын хамгаалалтыг холбогдох тооцоонуудыг хийж сонгох, микропроцессорын хамгаалалтын төхөөрөмжүүд нь WAMS-д холбогдох боломжтой RJ-45 порттой байх, PMU функцтэй байх,

9.4.9 Үндсэн болон бэлтгэл хамгаалалтууд нь тусдаа бие даасан реле болон тэжээлийн блоктой, IP55 стандартын шаардлага хангасан хамгаалалтын панель дээр суурилагдсан байх,

9.4.10 Реле хамгаалалт автоматикуудын тавил тооцоог “ДҮТ” ТӨХХК-аар хийлгэн, хянуулах,

9.4.11 Аваарын үеийн процессыг бүртгэх төхөөрөмжөөр тоноглох,

9.5 Дэд станцын 35 кВ-ын хуваарилах байгууламж:

9.5.1 35 кВ-ын хуваарилах байгууламж нь систем шин бүхий энгийн схемтэй байх,

9.5.2 35 кВ-ын шинийн утсыг тооцоогоор сонгож, утасны механик ачаалалд тохирсон шинийн портал, тусгаарлагч элемент, дагалдах төмөр хийцийг тооцоогоор сонгох,

9.5.3 35 кВ-ын гаргалгаа тус бүрд IEC стандартын шаардлага хангасан сүүлийн үеийн дэвшилтэт технологи бүхий фаз тус бүрийн удирдлагатай элегаз таслуур болон дагалдах тоноглолын хамт, газардуулгын хутга бүхий алсын удирдлагатай цахилгаан соронзон хоригтой хуурай салгуур бүхий тоноглолууд суурилуулах, цаашид өргөтгөх боломжтой байхаар зураг төсөлд тусгах,

9.5.4 35 кВ-ын систем шин нь трансформаторын оролт, гаргалгааны тоог зураг төсөл боловсруулах шатанд ашиглагч байгууллага “ЦДҮС” ТӨХК, “УБЦТС” ТӨХК-уудтай зөвшилцөх, цаашид өргөтгөх боломжтой байхаар төлөвлөж зай талбайг зурагт тусгах,

9.5.5 Трансформаторын оруулга, гаргалгааны таслуурыг АПВ төхөөрөмжөөр болон удирдлагын түлхүүрээр /гараар/ синхрон

хяналттай залгах боломжтой байх. Синхрон хяналтын мэдээллийг /шугам, шинийн хүчдэл, өнцөг, давтамж/ хүчдэлийн трансформатороос авч байх.

9.5.6 АПВ-гийн төхөөрөмжийг шугамын хүчдэл ба шинийн хүчдэл хянах боломжтойгоор сонгох,

9.5.7 35 кВ-ын гаргалгаанууд болон трансформаторуудын гаргалгаа тус бүрд ачаалалд тохирсон коэффициент бүхий гүйдэл, хүчдэл, бодит, хуурмаг чадлын хэмжүүр тавих,

9.5.8 35 кВ-ын хуваарилах байгууламжийн шинийн болон шугам, трансформаторуудын үндсэн, бэлтгэл хамгаалалтуудыг олон улсын IEC-61000, IEC-60258, IEC-60068, IEC-61850 зэрэг стандартын шаардлага хангасан орчин үеийн микропроцессорын хамгаалалтыг холбогдох тооцоонуудыг хийж сонгох,

9.5.9 Үндсэн болон бэлтгэл хамгаалалтууд нь тусдаа бие даасан реле болон тэжээлийн блоктой, IP55 стандартын шаардлага хангасан хамгаалалтын панель дээр суурилагдсан байх,

9.5.10 Реле хамгаалалт автоматикуудын тавил тооцоог “ДҮТ” ТӨХХК-аар хийлгэн, хянуулах,

9.5.11 Дэд станцын технологийн процессыг хянах, удирдах автомат систем удирдлага, хяналтын систем /HMI/-тэй байх,

9.5.12 Аваарын үеийн процессыг бүртгэх төхөөрөмжөөр тоноглох,

9.6 Дэд станцын 10 кВ-ын хуваарилах байгууламж:

9.6.1 10 кВ-ын хуваарилах байгууламж нь секцлэгдсэн шинтэй, оролтын 2, дотоод хэрэгцээний трансформаторын 2, хүчдэлийн трансформаторын 2, секц холбогч таслуурын 1, секц холбогч салгуурын 1, компенсацлах реакторын 2, гарсан шугамын 22, нийт 32 ячейктай байна, Зураг төсөл боловсруулах шатанд ашиглагч байгууллага “УБЦТС” ТӨХК-тай зөвшилцөх,

9.6.2 10 кВ-ын хуваарилах байгууламжийн кабелийн туннел, тоноглолд засвар үйлчилгээ хийх зай талбайг норм дүрмийн шаардлагад нийцсэн байхаар зураг төсөлд тооцох,

9.6.3 10 кВ-ын хуваарилах байгууламжийн бүх ячейкийг сүүлийн үеийн олон улсын стандартын шаардлага хангасан, вакуум таслуур бүхий иж бүрэн ячейкуудыг суурилуулж, хэмжилт туршилт хийж бүрэн ажиллагаанд оруулах,

9.6.4 10 кВ-ын ячейк нь олон улсын IEC-61850 цуврал стандартын шаардлага хангасан микропроцессорын реле хамгаалалттай байх,

9.6.5 Шинээр суурилуулах ячейкууд нь нумын хамгаалалт, ихсэх болон шууд гүйдлийн хамгаалалт, газардлагын хамгаалалт бүхий микро процессорын хамгаалалттай байх,

9.6.6 Шинээр суурилуулах ячейкуудад хэрэглэгчийн ачаалалд тохирсон коэффициент бүхий 0.2 нарийвчлалттай гүйдлийн трансформатор, кабелийн үзүүрт тооцооны үндсэн дээр хэт хүчдэл хязгаарлагч /ОПН/ сонгох, Кабелийн туннел болон ячейкуудад тэсэрдэг галын хор байрлуулах /Бурон-2.0, ОСП-1/

9.6.7 Ячейкуудын гүйдлийн трансформаторын коэффициентыг хэрэглээ, ачаалалтай ашиглагч байгууллага “УБЦТС” ТӨХК-тай зөвшилцөж сонгох,

9.6.8 10 кВ-ын хатуу шинийг тооцоогоор сонгож хийх,

9.6.9 10 кВ-ын ячейкуудад реле хамгаалалтын тооцоог хийж, тавил тохируулах,

9.6.10 10 кВ-ын хаалттай хуваарилах байгууламжийн барилгыг барьж цаашид шинээр ячейк нэмж суурилуулахаар өргөтгөх боломжтой байх. Хаалттай хуваарилах байгууламжийн гэрэлтүүлэг, халаагуурыг сүүлийн үеийн эрчим хүчний хэмнэлттэй тоног төхөөрөмж сонгох,

9.6.11 10 кВ-ын тоног төхөөрөмжүүдийн суурилуулалт болон газардуулгыг техник ашиглалтын норм, дүрмийн шаардлагад нийцүүлэх,

9.6.12 110/35/10 кВ-ын хуваарилах байгууламжийн аянгын хамгаалалт, гэрэлтүүлэг, газардуулагын зураг төслийн шатанд ашиглагч байгууллага “ЦДҮС” ТӨХК-тай зөвшилцөх,

9.6.13 10 кВ-ын хуваарилах байгууламжийн барилга нь тоосгоор баригдсан байх,

9.6.14 Дэд станцын ил хуваарилах байгууламжийн талбайг тэгшилж хайргаар дүүргэн борооны ус тогтхооргүй, үерийн ус зайлуулах сувагтай байхаар шийдэх,

9.6.15 Дэд станц нь өргөст тор бүхий том, жижиг 2 хаалгатай бетонон хашаагаар хамгаалагдсан байх,

9.6.16 Дэд станцын ил болон хаалттай хуваарилах байгууламжийг алсаас удирдах боломжтой, хөдөлгөөн, дулаан илрүүлэгч бүхий IP камерийн хяналтын системтэй байх

9.7 Техникийн нөхцөлийн дагуу шинээр суурилуулах тоноглолууд нь өмнө ашиглагдаж байгаагүй шинэ байх, кабель шугам, трансформаторууд нь сүүлийн үеийн байгаль орчинд ээлтэй, дэвшилтэд техник технологи бүхий байх. Нэгдсэн сүлжээний дүрэмд заасны дагуу ■10%-ийн хүчдэлийн хэлбэлзэлд хэвийн ажиллах,

9.8 Хуваарилах байгууламж, дэд станцуудад Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 06 дугаар сарын 20-ны өдрийн 339 дугаар

	тогтоолын хавсралтаар батлагдсан “Галын аюулгүй байдлын үндсэн дүрэм”-д заасны дагуу галын аюулгүй байдлыг хангах, 9.9 Шугам, дэд станцын гүйцэтгэлийн зургийг гаргаж, ашиглагч байгууллага "ЦДҮС" ТӨХК-д хүлээлгэн өгөх, гүйцэтгэлийн зургийг гаргахдаа кабель шугамын холболтын муфтуудыг заасан, бусад инженерийн шугам сүлжээ, авто замтай огтлолцсон хэсгийн зүсэлтийг тусгах,
10. Реле хамгаалалт, автоматикийн байгууламжид тавих шаардлага	10.1 Энэхүү техникийн нөхцөлийн дагуу суурилуулах реле хамгаалалт, автоматикийн тоног төхөөрөмжүүд, удирдлага, хяналт, мэдээллийн системүүд нь “Бодлогын бичиг баримт батлах тухай” Эрчим хүчний сайдын 2019 оны 335 дугаар тушаалаар батлагдсан “Реле хамгаалалт, системийн автоматикийн талаар баримтлах бодлогын баримт бичиг”, “Эрчим хүчний салбарт баримтлах мэдээллийн технологийн бодлогын баримт бичиг”-шаардлагуудыг бүрэн хангах, хангагч байгууллага "ЦДҮС" ТӨХК, "УБЦТС" ТӨХК-уудтай зураг төсөл боловсруулах шатанд зөвшилцсөн байх. 10.2 Хуваарилах байгууламж, шугам, дэд станцын оруулга, гаргалгааны тоноглолуудад олон улсын стандартын шаардлага хангасан орчин үеийн микропроцессорын хамгаалалтыг холбогдох богино залгааны тооцоонуудыг хийж, ашиглагч байгууллага "ЦДҮС" ТӨХК, "УБЦТС" ТӨХК-уудтай зөвшилцөн сонгох. 10.3 Реле хамгаалалт автоматикийн тавилын тооцоог хангагч байгууллага "ДҮТ" ТӨХХК-аар хийлгэх.
11. Реактив чадлын зохицуулалт	...
12. Цахилгаан эрчим хүчний чанарыг хянах хэрэгсэл, чанарын үзүүлэлтийг тогтворжуулах төхөөрөмжийн хэрэгцээ	...
13. Нэг маягийн зураг төсөл хэрэглэх зөвлөмж	13.1 Зургийн даалгаврыг эрх бүхий байгууллагаас авах. 13.2 Ажлын зураг төсөл боловсруулахдаа Монголын Засгийн 2019 оны 108 дугаар тогтоолын 5 дугаар зүйлд заасны дагуу эрх бүхий байгууллага болон "ЦДҮС" ТӨХК, "УБЦТС" ТӨХК-уудтай зөвшилцсөн байх. 13.3 Зураг төсөл боловсруулах шатанд холболт хийх цэг, ячейкны дугаар, шуурхай ажиллагааны нэр, зарчмын схем, хоёрдогч

	хэлхээний зургийг ашиглагч байгууллага "ЦДҮС" ТӨХК, "УБЦТС" ТӨХК-уудтай зөвшилцөх.
14. Гэнэтийн гэмтэл саатал, аваарын үед ашиглах бэлтгэл тэжээл, бие даасан цахилгааны үүсгүүр суурилуулах шаардлага	...
15. Цахилгаан тоног төхөөрөмжийн ашиглалт, аюулгүйн ажиллагааны байдал	15.1 “Эрчим хүчний тухай” хуулийн 30.1.8 “Өөрийн эзэмшлийн шугам, сүлжээ, тоног төхөөрөмжийн бүрэн бүтэн, аюулгүй байдал, засвар үйлчилгээ, баталгаажуулалтыг бүрэн хариуцах” гэж заасны дагуу өөрийн ашиглалт үйлчилгээний зааг доторх цахилгаан тоног төхөөрөмжид байнгын үзлэг шалгалт хийх, хэвийн бус ажиллагаатай үед өөрсдийн хөрөнгөөр засвар үйлчилгээг хийлгэх. 15.2 “Эрчим хүчний тухай” хуулийн 30.1.13 “Нийтийн эзэмшлийн орон сууцны барилга барих тохиолдолд барьсан эрчим хүчний дэд станц, шугам, тоноглолыг тусгай зөвшөөрөл эзэмшигчид шилжүүлэх гэж заасны дагуу хангагч байгууллага "ЦДҮС" ТӨХК-д хүлээлгэн өгөх.
16. Техникийн нөхцөлийн хүчинтэй хугацаа	16.1 Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 03 дугаар сарын 18-ны өдрийн 97 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Цахилгаан эрчим хүч хэрэглэх дүрэм”-ийн 2.9-д заасны дагуу /2 жилийн хугацаанд/ хүчинтэй. 16.2 Техникийн нөхцөлийн хүчинтэй хугацаанд Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 03 дугаар сарын 18-ны өдрийн 97 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Цахилгаан эрчим хүч хэрэглэх дүрэм”-ийн 2.13-д заасны дагуу техникийн нөхцөлийн дагуу зураг төслийн байгууллагаар хийлгэж, холбогдох байгууллагаар хянуулж, эрх бүхий байгууллагаар магадлал хийлгэж баталгаажуулсан байна. 16.3 Техникийн нөхцөлийн хүчинтэй хугацааг сунгуулахдаа хугацаанд Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 03 дугаар сарын 18-ны өдрийн 97 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Цахилгаан эрчим хүч хэрэглэх дүрэм”-ийн 2.16-д заасны дагуу баталгаажуулсан зураг төслийг ирүүлнэ. Хэрэв баталгаажуулсан зураг төсөл ирүүлээгүй тохиолдолд техникийн нөхцөлийн хүчинтэй хугацааг сунгахгүй.
17. Дагаж мөрдөх хууль, дүрэм, журам	17.1 Дэд станц, цахилгаан дамжуулах шугамын байршлын зургийг эрх бүхий байгууллагаар хийлгэж, тухайн орон нутгийн газар зохион

байгуулалт, хот төлөвлөлтийн газраар батлуулан, мэдээллийн санд оруулсан байх,
17.2 Цахилгаан шугам сүлжээнд холбогдох явцад трассын дагуу дайрч гарах зам талбай, бут сөөгийг сэргээх зардлыг төсөвт тусгах,
17.3 Шугам, дэд станцын зураг төсөл боловсруулах, угсралт, туршилт, тохируулгын ажлыг “Цахилгаан байгууламжийн угсралтын дүрэм” (2003 он), Эрчим хүчний тоног төхөөрөмжийн техник ашиглалтын дүрэм, Цахилгаан байгууламжийн ашиглалтын үед мөрдөх аюулгүй ажиллагааны дүрмийн дагуу эрчим хүчний барилга байгууламжийн зураг төсөл ба угсралтын ажлыг гүйцэтгэх "Тусгай зөвшөөрөл" бүхий мэргэжлийн компаниар гүйцэтгүүлэх,
17.4 “Эрчим хүчний тухай” хуулийн 29.1.9 “Хангагч нь хэрэглэгчийн өмчлөлийн шугам, дэд станцаас нутаг дэвсгэрийн хэтийн төлөвийн үндсэн дээр өөр бусад хэрэглэгчийг нэмж холбох эрхтэй” гэж заасны дагуу өөрийн тоноглолоос хангагч байгууллагын зөвшөөрлөөр шинээр хэрэглэгч нэмж холбуулах үүрэгтэй.

18. Техникийн нөхцөлийн хүчингүйд тооцох заалт

18.1 Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 03 дугаар сарын 18-ны өдрийн 97 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Цахилгаан эрчим хүч хэрэглэх дүрэм”-ийн 2.16, 2.17-д заасан доорх заалтуудыг мөрдлөг болгоно.
-2.16 Техникийн нөхцөлийн хүчинтэй хугацаанд холболт хийгдээгүй тохиолдолд хугацаа дуусахаас 2 сарын өмнө сунгуулах хүсэлтээ энэ дүрмийн 2.13-д заасан баталгаажуулсан зураг төслийн хамт техникийн нөхцөл олгосон байгууллагад ирүүлнэ.
-2.17 дараах тохиолдолд олгосон техникийн нөхцөлийг хүчингүйд тооцно. Үүнд:
-2.17.1. хүчинтэй хугацаа дууссан;
-2.17.2. техникийн нөхцөл авахдаа шаардлагатай өгөгдлүүдийг буруу тодорхойлсон, баримт бичгийг хуурамчаар үйлдсэн;
-2.17.3. холбогдох цэгийн хүчин чадлаас хэтрүүлсэн;
-2.17.4. дамжуулагчаас санал аваагүй, өөрийн эзэмшлийн түгээх сүлжээнд иргэн, хуулийн этгээдэд техникийн нөхцөл олгохдоо дамжуулах сүлжээнд холбогдох техникийн нөхцөлд заагдсан хүчин чадлаас хэтрүүлсэн.
18.2 Олгосон чадлаас хэтрүүлэн чадал ашигласан тохиолдолд